



ТӨВ АЙМГИЙН АРХУСТ НЕҮЙЛЧИЛГЭЭ

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Лавлах зүйлс байвал доорх хаягаар

холбоо барина уу:

Аймгийн Ерөнхий Аудитор

Л.Жаргалсайхан

Утас: 70272582

И-мэйл

Аудитын багийн аудитор

Г.Бадар-Ууган

Утас: 70273465

И-мэйл gaagii_777 @ yahoo.com

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг Төрийн
байгууллагуудын ордон

• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4
• Гол шийдлүүд	6
• Залруулаагүй алдаа	8
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	8
• Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлт.....	8
• Аудитын санал дүгнэлт	8

БЗДаргын 2013 оны санхүүгийн тайланд**ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид ЗДТГазрын 2013 оны санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба ЗДТГазрын төсвийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Архуст сумын ЗДТГазрын тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

1. БЗДаргын Мөнгөн гүйлгээний тайлангаар урсгал санхүүжилт 21362,5 мянган төгрөг, СТСХэлтсийн тулган баталгаажуулалтаар оны эхний үлдэгдэл 1441,4 мянган төгрөг, санхүүжилт 21362,5 мянган төгрөг, орлого 989,0 мянган төгрөг байна. Нийт зарцуулалт 23792,9 мянган төгрөг байна. Энэ нь орлого зарлага 989,0 төгрөгөөр дутуу бүртгэгдсэн байна. Энэ орлого нь нэр данс зөрүүтэй алдаатай гүйлгээ хийгдсний улмаас буцаж орж ирсэн орлого зарлага байна.
2. БЗД-т тайлант онд түлш халаалтын зардалд 1028,0 мянган төгрөг, гэрэл цахилгаан зардалд 519,1 мянган төгрөг нийт 1547,1 мянган төгрөг батлагдснаас түлш халаалтын зардалд 674,5 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 872,5 мянган төгрөг нийт 1547,0 мянган төгрөг зарцуулж хэмнэлт, хэтрэлт гараагүй байна. Түлш халаалтын зардалаас 35,0 мянган төгрөгийн хог үүсгэсний хураамж, 165,6 мянган

- төгрөгийн гэрэл цахилгааны төлбөр, 472,0 мянган төгрөгийн ахмадын хүндэтгэлийн зардал гаргаж үр дүнгийн тайланд түлш халаалтын зардлаар тайлагнасан. Төсвийг зориулалт бусаар зарцуулсан, зардлын бүлэг хооронд шилжүүлэх зөвшөөрөлгүйгээр зардал гаргасан зөрчил байна.
3. БЗД-т тайлант онд бичиг хэргийн зардалд 174,2 мянган төгрөг, ном хэвлэлийн зардалд 151,4 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 192,0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 972,0 мянган төгрөг нийт 1489,6 мянган төгрөг батлагдснаас бичиг хэргийн зардалд 168,9 мянган төгрөг, ном хэвлэлийн зардалд 149,7 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 188,9 төгрөг, тээвэр шатахууны зардалд 980,1 мянган төгрөг нийт 1487,6 мянган төгрөгийн зардал гаргаж 2,0 мянган төгрөгийн хэмнэлт гарсан байна. Бичиг хэргийн материал БМ-ын тодоруулгын тайлангаар 640,6 мянган төгрөгөөр орлого, 286,7 мянган төгрөгөөр зарлага тайлагнасан нь бусад зардлаас бичиг хэргийн материал бэлгэсэнтэй холбоотой байна. Бусад зардлаас 471,7 мянган төгрөгийн бичиг хэргийн материал бэлтгэсэн байна. Шуудан холбооны зардлаас 70,7 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал гаргаж 25,0 мянган төгрөгийн бичиг хэргийн зардлыг шуудан холбооны зардалд бичсэн. Ном хэвлэлийн зардлаас 128,2 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал гаргаж 128,2 мянган төгрөгөөр ном хэвлэлийн зардалд бичсэн.
4. ИТХурлын шатахууны зардлыг БМ-ын тодоруулгын тайлангаар 1264,4 мянган төгрөгийн орлого 1264,4 мянган төгрөгийн зардал бүртгэгдсэн байна. Энэ нь сургалт семинарын зардлаас 46,0 мянган төгрөг, гэмх хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 340,5 мянган төгрөгийн шатахууны зардал гаргаж тухайн зардалдаа бичилт хийсэнтэй холбоотой байна.
5. ИТХурлын мөнгөн хөрөнгийн журналаар оны эхний үлдэгдэл 8,4 мянган төгрөг төсвөөс урсгал санхүүжилт 30791,4 мянган төгрөг, өөрийн орлого 82,0 мянган төгрөг нийт зарлагын дүн 30965,3 мянган төгрөг тайлант оны жилийн эцсийн үлдэгдэл 0,0 байна гэж мэдээлэгдсэн байна. 12-р сарын хяналтын түвшиний хуулгаар тайлант онд орлогын буюу ДТ гүйлгээ 30881,8 мянган төгрөг, зарлагын буюу КТ гүйлгээ 30881,8 мянган төгрөг эцсийн үлдэгдэл 0 байна. Төрийн сангаар орсон мөнгөн орлого зарлагын гүйлгээнээс 83,5 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь 12-р сард данс андуурч гүйлгээ хийснээс буцаж орж ирэн гарсан гүйлгээ байна. Үүнийг бүртгэлд тусгаагүй байна.
6. ЗДТГазар нь түлш халаалтын зардлаас 40000 төгрөгийн хог үүсгэсний хураамжийн зардал, ахмадын хүндэтгэлийн зардалд 288000 төгрөг, цэвэр бохир усны зардлаас 216200 төгрөгийн цэвэрлэгээний материалын зардал гаргаж зарцуулсан, зарцуулалтыг гаргасан зардалдаа буруу тайлагнасан алдаа илэрсэн.
7. ЗДТГазраас 2013 оны 20 тоот засаг даргын захирамжаар Сумын сайн малчин шалгаруулж 5 иргэнд 250000 төгрөгийн мөнгөн шагнал олгосноос ХАОАТ тооцоогүй 2013 оны А/103 тоот захирамжаар тээврийн хяналтын үзлэг оншилгооны үйлчилгээ үзүүлсэн ажлын хэсгийн хоол унд байраар хангахад зориулж 160000 төгрөгийг хүнсний материалд зарцуулсан зөрчил илэрсэн.
8. Хөрөнгийн тооллогыг жилд нэг удаа хийдэг. ЗДТГазрын даргын тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс томилон

тооллогыг 2013.12.25-2013.12.31-ны хооронд явуулсан байна. Тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тооллогын бүртгэлийн маягтаар бүртгэн тоолсон байна. Мөн тоолсон эд хөрөнгийг зурагжуулан тайланд хавсаргасан байна. Тооллогын комисс хүн бүрээр тооллогын бүртгэл, эд хөрөнгийн картаар бүртгэлж, тооллого хийсэн тухай илтгэх хуудас тайлан, тэмдэглэл хөтлөөгүй байна.

9. Зардлын бүлэг болон дангаар хянагдах зардлын бүлэглэлээс зардлыг санхүүжүүлэхдээ бичилтийн алдаа гаргасан байна.
10. Төрийн хяналт шалгалтын тухай хууль"-ийн 6.4-д заасныг үндэслэн "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 311 дүгээр тогтоолоор баталласан. Энэхүү нийтлэг журмын зорилго нь аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах ба тус журамд нийцүүлэн аж ахуйн нэгж байгууллага бүр үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналтын журам"-ыг боловсруулж, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажилтанг томилон ажиллуулаагүй байна.

Ерөнхий менежерээс ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа

-Илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү

- Ерөнхий Аудитор 2014.03.08-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ерөнхий нягтлан бодогч Б.Уламбаяр бидэнтэй хамтран ажилласан ажилчдын байнгын дэмжлэг туслалцаа бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

Төв Аймгийн Аудитын Газар

2014.03.08

- Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа

Танилцуулга

1. Бид Аймгийн Архуст сумын ЗДТГазрын 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Аймгийн Архуст сумын ЗДТГазрын ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Архуст сумын ЗДТГазар тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийхэд

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Архуст сумын ЗДТГазрын хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид Аймгийн Архуст сумын ЗДТГазрын тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

4. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Аймгийн Архуст сумын ЗДТГазрын удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1. Санхүүгийн дотоод хяналтын талаар

- Төрийн хяналт шалгалтын тухай хууль"-ийн 6.4-д заасныг үндэслэн “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 311 дүгээр тогтоолоор баталласан. Энэхүү нийтлэг журмын зорилго нь аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах ба тус журамд нийцүүлэн аж ахуйн нэгж байгууллага бүр үйл ажиллагааны онцлогт тохирсон “Дотоод хяналтын журам”-ыг боловсруулаагүй, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажилтанг томилон ажиллуулаагүй байна.

2. Орлогын талаар

- Орлого санхүүжилтийг мөнгөн харилцахын журналаас SORT FILTER-ийг ашиглан эх үүсвэрийг бүрэн ангилан тусгасныг шалгахад орлого, санхүүжилтийг бүрэн бүртгэсэн байна.
- БЗДаргын 2013 оны Батлагдсан төсөв 21362500 төгрөгийг бүрэн авч эх үүсвэрийг бүрдүүлсэн байна. Мөнгөн гүйлгээний тайлангаар урсгал санхүүжилт 21362,5 мянган төгрөг, СТСХэлтсийн тулган баталгаажуулалтаар оны эхний үлдэгдэл 1441,4 мянган төгрөг, санхүүжилт 21362,5 мянган төгрөг, орлого 989,0 мянган төгрөг байна. Нийт зарцуулалт 23792,9 мянган төгрөг байна. Энэ нь орлого зарлага

989,0 төгрөгөөр дутуу бүртгэгдсэн байна. Энэ орлого нь нэр данс зөрүүтэй алдаатай гүйлгээ хийгдсний улмаас буцаж орж ирсэн орлого зарлага байна.

- ИТХурлын Мөнгөн гүйлгээний тайлангаар урсгал санхүүжилт 30791,4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 82,0 мянган төгрөг, нийт 30873,4 мянган төгрөгийн эх үүсвэр тайлагнагдсан. Санхүүгийн үр дүнгийн тайлангаар урсгал санхүүжилт 30791,4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 82,0 мянган төгрөг нийт орлого 30873,4 мянган төгрөгийн эх үүсвэр тайлагнагдсан байна. Урсгал санхүүжилт, орлого мөнгөн гүйлгээний тайлан болон Үр дүнгийн тайланд үнэн зөв тайлагнасан байна.
- ЗДТГазрын Мөнгөн гүйлгээний тайлангаар урсгал санхүүжилт 203280832 төгрөг, нийгмийн даатгалын сангийн орлого 708375 төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 1069000 төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 9375060 төгрөг нийт 214433267 төгрөгийн эх үүсвэр тайлагнагдсан. Санхүүгийн үр дүнгийн тайлангаар урсгал санхүүжилт 203280832 төгрөг, нийгмийн даатгалын сангийн орлого 708375 төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 1069000 төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 9375060 төгрөг хөрөнгийн орлого 230618800,93 төгрөг нийт 445052067,93 төгрөгийн орлого тайлагнагдсан байна. Үнэ төлбөргүй авсан хөрөнгийн орлогыг үр дүнгийн тайланд үнэн зөв тайлагнасан байна.

3. Мөнгөн хөрөнгийн талаар

- БЗДаргын харилцах дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад төрийн сангийн дансаар 21362,5 мянган төгрөгийн санхүүжилт, 989,0 мянган төгрөгийн орлого, 23792,9 мянган төгрөгийн зарлага гарч 0 төгрөгийн үлдэгдэлтэйгээр Төрийн сангийн хяналтын түвшиний хуулгаар гарсан байна.
- ИТХурлын мөнгөн гүйлгээний тайлангаар урсгал санхүүжилт 30791,4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 82,0 мянган төгрөг, СТСХэлтсийн тулган баталгаажуулалтаар 30791,4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 82,0 мянган төгрөг зөрүүгүй төгрөг байна. Оны эхэнд 8415 төгрөгийн үлдэгдэлтэй байсан оны эцэст 159417 төгрөгийн үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.
- Тайлант онд сар бүр төрийн сангаас хяналтын түвшиний хуулгаар орлогын буюу ДТ гүйлгээ 214433267, зарлагын буюу КТ гүйлгээ 215087515 төгрөг байгаа нь програмаарх мөнгөн орлого зарлагын гүйлгээ үлдэгдэл тохирч байна. Санхүүгийн байдлын тайлан болон Мөнгөн гүйлгээний тайлангаар оны эхэнд 654248 төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Харилцахын мөнгөн орлого зарлагын журналар тайлант онд 214433267 төгрөгийн ажил гүйлгээ бүртгэгдснээс санхүүжилтийн орлого 203280832 төгрөг, нийгмийн даатгалын сангаас орсон хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмжийн санхүүжилт 708375 төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 1069000, үндсэн бус үйл ажиллагааны орлого 9375060 төгрөг нийт зарлагын гүйлгээ 215087515 төгрөгөөр тайлагдсан байна.
- Харилцахын баримтын бүрдэлийг шалгахад анхан шатны баримтын бүрдэлт сайн байна. Сар бүрийн мэдээг программ хангамжаар гаргаж байгааг хяналтын түвшингийн хуулгатай тулган шалгахад сарын мэдээндээ байгууллагын өр, авлагыг тогтмол тулгаж үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

4. Бараа материалын талаар

- БЗДаргын бараа материалын эхний үлдэгдэл 336600 төгрөг тайлангаар төсвийн хөрөнгөөр 2322154 төгрөгийн орлого нэмэгдэж, 2013300 төгрөгийн материал зарцуулж 645454 төгрөгний бараа материалын үлдэгдэлтэй гарсан байна.

- ЗДТГазар тайлант онд БМ-ын тодоруулга тайлангаар эхний үлдэгдэл 18000357,44 төгрөг төсвийн хөрөнгөөр 22302272 төгрөг, үнэ төлбөргүй 6813217,93 төгрөгийн материал нэмэгдэж 25229263 төгрөгийн материал зарцуулж, 1128826 төгрөгийн материал акталж устган 20687758,37 төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.
 - Бараа материалын үлдэгдэл, санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдэл, тодруулгын тайлангийн үлдэгдлийг тулган шалгахад зөрүү гараагүй.
 - Бараа материалын тооллогыг цаг хугацаанд хуулийн дагуу хийж гүйцэтгэсэн байна. Бараа материалын үлдэгдэл няравын материалын үлдэгдэлтэй зөрүүгүй таарч байна.
5. Үндсэн хөрөнгийн талаар
- Хөрөнгийн тооллогыг жилд нэг удаа хийдэг. ЗДТГазрын даргын тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс томилогдсон тооллогыг 2013,12,25-2013,12,31-ны хооронд явуулсан байна. Тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тооллогын бүртгэлийн маягтаар бүртгэн тоолсон байна. Мөн тоолсон эд хөрөнгийг зурагжуулан тайланд хавсаргасан байна. Тооллогын комисс хүн бүрээр тооллогын бүртгэл, эд хөрөнгийн картаар бүртгэлж, тооллого хийсэн тухай илтгэх хуудас тайлан, тэмдэглэл хөтлөөгүй байна
 - Үндсэн хөрөнгийг үнэн зөв ангилан бүртгэсэн тайлант онд хөрөнгө оруулалтаар барилга байгууламжид цагдаагийн кубон 61250,0, автобусны буудал 3000,0, ноёншанд багт автобусны буудал 3000,0, ноёншанд багийн хогийн цэгийн хашаа 3000,0, 37-р талбайн худаг 15000,0, булагтайд малын худаг 5000,0, 37-р талбайн хашаа 5000,0, нийтийн бие засах газар 3500,0, төвийн ундны худаг засвар 1800,0, нарст багийн хогийн цэгийн засвар 2000,0, зочид буудлын засвар 8307,0 мянган төгрөг нийт 110857,0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмжид нөүтбүүк 918,3, сум хөгжүүлэх сангаас принтер 189,0, гэрэлтүүлэг 11496,0, гэрэлтүүлэг 10000,0, скайнер 1300,0, жипийс 300,0, гэрэлтүүлэг 4160,2, ХХААЖДҮГазраас 34404,7 нийт 62768,2 мянган төгрөг, тавилга эд хогшилд сум хөгжүүлэх сангаас 409,8, ХХААЖДҮГазраас 937,2, гэр 10000,0, хүүхдийн тоглоом 10000,0, ус зөөлрүүлэгч 15828,2, буудлын тавилга 12020,0 нийт 49195,2 мянган төгрөг, бусад хөрөнгөд самбар 985,0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Тайлант онд үндсэн хөрөнгөнөөс сумын ИТХ-ын 2013.05.15-ны 60 тоот тогтоолоор 8276,3 мянган төгрөгийн хөрөнгө акталж устгасан байна.
6. Бараа үйлчилгээний зардал
- БЗДарга
 - тайлант онд түлш халаалтын зардалд 1028,0 мянган төгрөг, гэрэл цахилгаан зардалд 519,1 мянган төгрөг нийт 1547,1 мянган төгрөг батлагдснаас түлш халаалтын зардалд 674,5 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 872,5 мянган төгрөг нийт 1547,0 мянган төгрөг зарцуулж хэмнэлт, хэтрэлт гараагүй байна. Түлш халаалтын зардалаас 35,0 мянган төгрөгийн хог үүсгэсний хураамж, 165,6 мянган төгрөгийн гэрэл цахилгааны төлбөр, 472,0 мянган төгрөгийн ахмадын хүндэтгэлийн зардал гаргаж үр дүнгийн тайланд түлш халаалтын зардлаар тайлагнасан. Төсвийг зориулалт бусаар зарцуулсан, зардлын бүлэг хооронд шилжүүлэх зөвшөөрөлгүйгээр зардал гаргасан зөрчил байна.
 - Бичиг хэргийн материал БМ-ын тодоруулгын тайлангаар 640,6 мянган төгрөгөөр орлого, 286,7 мянган төгрөгөөр зарлага тайлагнасан нь бусад зардлаас 471,7 мянган төгрөгийн бичиг хэргийн материал бэлгэсэнтэй холбоотой байна. Шуудан холбооны зардлаас 70,7 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал гаргаж 25,0 мянган төгрөгийн бичиг хэргийн зардлыг шуудан холбооны зардалд бичсэн. Ном хэвлэлийн зардлаас 128,2 мянган төгрөгийн

бичиг хэргийн зардал гаргаж 128,2 мянган төгрөгөөр ном хэвлэлийн зардалд бичсэн зөрчилүүд байна.

- Зардлын бүлэг болон дангаар хянагдах зардлын бүлэглэлээс зардлыг санхүүжүүлэхдээ бичилтийн алдаа гаргасан нийтлэг зөрчил байна.

- **ИТХУрал**

- Шатахууны зардлыг БМ-ын тодоруулгын тайлангаар 1264,4 мянган төгрөгийн орлого 1264,4 мянган төгрөгийн зардал бүртгэгдсэн байна. Энэ нь сургалт семинарын зардлаас 46,0 мянган төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 340,5 мянган төгрөгийн шатахууны зардал гаргаж тухайн зардалдаа бичилт хийсэнтэй холбоотой байна.

- **ЗДТГазар**

- Тайлант онд түлш халаалтын зардлаас 40000 төгрөгийн хог үүсгэсний хураамжийг гаргаж үр дүнгийн тайлангаар түлш халаалтын зардлаар тайлагнасан, мөн ахмадын хүндэтгэлийн зардалд 288000 төгрөгийг түлш халаалтын зардлаас гаргаж үр дүнгийн тайлангаар түлш халаалтын зардалд тайлагнасан, цэвэр бохир усны зардлаас цэвэрлэгээний материалд 216200 төгрөгийг гаргаж зарцуулсан үр дүнгийн тайланд цэвэрлэгээний материалын зардал 216200 төгрөгөөр цэвэр бохир усны зардалд бичсэн, төсөв хүрдэггүй гэсэн шалтгаанаар төсвийн зохицуулалт хийх журмаар зардалд хооронд шилжүүлэх хүсэлтгүйгээр зориулалтын бус зардалд зарцуулсан зөрчил илэрсэн. Халаалтын зардлаас 104920 төгрөгийн шатахууны зардал гарсан
- 2013 оны 20 тоот засаг даргын захирамжаар Сумын сайн малчин шалгаруулж 5 иргэнд 250000 төгрөгийн мөнгөн шагнал олгосноос ХАОАТ тооцоогүй 2013 оны А/103 тоот захирамжаар тээврийн хяналтын үзлэг оншилгооны үйлчилгээ үзүүлсэн ажлын хэсгийн хоол унд байраар хангахад зориулж 160000 төгрөгийг хүнсний материалд зарцуулсан зөрчил илэрсэн.

7. Авлага, өглөгийн талаар

- Байгууллагуудын өглөг, авлагын журналыг, харилцахын журнал, бараа материалын тодруулгын тайлангийн орлогуудтай тулган шалгахад зөрүү гараагүй.
- Авлага өглөгийн журналыг ерөнхий дэвтэрийн данстай тулган баталгаажуулсан.
- БЗДаргын тайлант оны эхний үлдэгдэл хувь хүмүүсээс авах багийн хөгжлийн сангийн зээлийн авлага 2000000 төгрөг, НБББББ-ын авлага 334754 төгрөг байсан ба жилийн эцсээр 0 төгрөг болж буурсан байна. НБББББ-ыг орлогод авч орлого буурсан мөн багийн хөгжлийн сангийн зээлийн авлага 2000000 төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага руу нэгтгэсэн байна. Тайлант оны эцэст авлага өглөггүй гарсан байна
- ИТХурлын тайлант оны эхний үлдэгдэл болон оны эцсээр авлага бүртгэгдээгүй байна. Тайлант онд 24,0 мянган төгрөгийн өглөгтэй байсан ба оны эцсээр өргүй гарсан байна.
- ЗДТГазрын тайлант оны эхний үлдэгдэл 786,1 мянган төгрөг жилийн эцсээр өр авлагагүй гарсан байна. Тайлант онд өглөг авлагыг зөв ангилан бүртгэж тайлагнасан байна.

8. Цалингийн талаар

- Ажилтнуудын цалинг ЗГ-аас гаргасан сүлжээнд нийцүүлэн тогтоосон, бичигдсэн цалин НББ-ийн журнал, СХТ-ийн тоо дүнтэй тохирсон, цалингаас суутган тооцоо хийж байгаа тооцоолол үнэн зөв хийгдэж байна.
- Ажилтнуудын цалинг Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын тогтоолын үндэслэн байгууллагын даргын тушаалаар олгожээ.

- Цалингийн цэсэнд бүрэн гарын үсэг зуруулаагүй зөрчил байна.
- Тамгын газрын үйлчлэгч ажилтай Ц.Цэрэнбуян нь Хөдөлмөрийн тухай хуулийн 38.1.1 “Ажилтан санаачилсан” үндэслэлээр 2013.03.22-ны 22 тоот тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн байна. ЗДТГазрын даргын 2013.03.22-ны 23 тоот тушаалаар ажлаас халагдсны тэтгэмжийг албан тушаалын үндсэн цалингийн 3 сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээгээр тооцож цалингийн сангаас олгох шийдвэр гаргаж 722600 төгрөгийн тэтгэмж олгосон.
- 2013 онд өндөр насны тэтгэвэрт гарсан галч Ц.Равдандоржид ажлаас халагдсны тэтгэмж 1137423 төгрөг, жолооч С.Очирпүрэвт 1179534 төгрөгийн тэтгэмжийг цалингийн сангаас олгосон зөрчил байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 8 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Төсвийн бүрдүүлэлт зарцуулалтанд төсвийн тухай хуулийг баримтлаж ажиллах
- Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ыг мөрдөж ажиллах

6. Эдгээр асуудлуудыг ААГ болон Архуст сумын БЗДарга авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

7. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг.

Тайлбар мэдүүлгийн захидал

8. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд БЗДаргын удирдлагаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

9. Аймгийн Аудитын газраас тус тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын газар

2014.03.08